



Олон улсын нисэх буудлын лоунж-д
“UnionPay виртуал картын Priority Pass”-р
үйлчлүүлэх **гарын авлага**


БҮРТГҮҮЛЭХ ЗААВАР

1

Карт идэвхжүүлснээс хойш 10 хоногийн дотор банкнаас доорх 2 кодыг таны бүртгэлтэй и-мэйл хаяг руу илгээнэ.

- Membership code (гишүүнчлэлийн дугаар)
- Password (нэг удаагийн нууц код)

Банкнаас и-мэйл ирсний дараа SocialPay-UnionPay виртуал кредит карт-"Приорити пасс - Бизнес лоунж" цэс дээр дарна.




2


И-мэйл хаягт ирсэн Membership code болон Password оруулан "Confirm Login" товчийг дарна.

3

Хувийн мэдээллээ шалган өөрийн шинэ нууц дугаарыг хийж бүртгэлээ үүсгэнэ.





ЛОУНЖИД НЭВТРЭХ ЗААВАР - ҮНЭГҮЙ НЭВТРЭХ




1
Membership code болон
өөрийн шинээр үүсгэсэн нууц
кодыг оруулан "Confirm Login"
товчийг дарна.

2
Airport lounge цэсийг сонгоно.




3
"Change" товч дээр даран
онгоцны буудал сонгох, "Use"
товч дээр дарж орох лаунжаа
сонгоно. Та жилд 6 удаа үнэгүй
ашиглах боломжтой.

4
Та QR кодыг Lounge-н
ажилтанд харуулж
нэвтэрнэ үү.



ЛОУНЖИД НЭВТРЭХ ЗААВАР - ТӨЛБӨР ТӨЛЖ НЭВТРЭХ





1
Airport lounge цэсийг сонгоно.

2

Санамж:


Та 6 удаагийн үнэгүй эрхээ ашиглаж дууссан бол 7 дахь удаагаас эхлэн төлбөрөө өөрөө төлөх болохыг анхаарна уу.



3
Та UnionPay виртуал кредит картыхаа дугаарыг оруулж "Payment" товчийг дарна уу.

4

Та QR кодыг Lounge-н ажилтанд харуулж нэвтэрнэ үү.



ҮЙЛЧЛҮҮЛЭХ ЭРХИЙН НӨХЦӨЛ

Энэхүү нисэх онгоцны буудлын үйлчилгээ нь зөвхөн Голомт банкны **UnionPay Platinum кредит** карт эзэмшигчдэд хамаарна.

Энэ үйлчилгээг ашиглахдаа нисэх онгоцны буудлын холбогдох **дүрэм журмыг** дагаж мөрдөх шаардлагатай.

Үйлчилгээг зөвхөн нисэх буудлын **амралтын танхимын ажиллах цагийн хүрээнд** ашиглах боломжтой. Ажлын цагаас гадуур үйлчилгээ авах боломжгүй.

Нисэх буудлын VIP амралтын танхимын стандарт **ашиглах хугацаа 2 цаг** байна. Үйлчилгээний хүртээмж нь тухайн амралтын танхимд бодитоор байгаа үйлчилгээний нөхцөлөөс хамаарна.

Нисэх буудлын VIP амралтын танхимын ашиглалтын талаар:

Амралтын болон баярын өдрүүдэд зорчигчдын хэт ачааллаас шалтгаалан үйлчилгээний хүртээмж хязгаарлагдаж, түр хугацаагаар үйлчилгээ үзүүлэх боломжгүй болох тохиолдол гарч болзошгүй.

Иймээс таны аялалд саад учрахаас сэргийлж, урьдчилан төлөвлөлт хийхийг зөвлөж байна.

Platinum карт эзэмшигч **жилд 6 удаагийн эрх** (карт эзэмшигч болон дагалдах хүний нийт эрх) ашиглах боломжтой.

Platinum карт эзэмшигчид сард **2 удаа тусгай хөнгөлөлттэй үнээр** амралтын танхимын эрх худалдаж авах боломжтой бөгөөд нэг удаагийн худалдан авалтаар 1 эрх авах боломжтой.

Сарын эрх хязгаартай тул эхэлж захиалсан хүн түрүүлж үйлчлүүлэх зарчмаар олгогдоно. Asia Prestige картын сарын урамшууллын хязгаар **100 эрх**.

Карт эзэмшигчийн үнэгүй нисэх буудлын амралтын эрх нь ашиглалт эхэлснээс хойш нэг жилийн хугацаанд хүчинтэй байна. Төлбөрийн карт нь 2 жил тул **2 дахь жилээс** 6 удаа үнэгүй эрх дахин сэргэнэ.

Карт эзэмшигчид энэхүү үйлчилгээг төлбөр төлж хөнгөлөлттэй үнээр авахдаа **UnionPay онлайн төлбөрийн системээр** дамжуулан худалдан авах шаардлагатай.

Карт эзэмшигчид худалдан авсан амралтын танхимын эрх нь **нэг сарын хугацаанд хүчинтэй** байх ба хугацаа дуусмагц хүчингүй болно. Буцаалт хийгдэхгүй.

Энэ үйлчилгээ нь зөвхөн **UnionPay Platinum** эзэмшигчид болон тэдний хамт яваа дагалдах хүн ашиглах зориулалттай. Үйлчилгээг бусдад шилжүүлэх, мөнгөн дүнгээр солих, өөр хөнгөлөлт эсвэл давуу эрхээр сольж авах боломжгүй.

Хэрэв үйлчилгээг ашиглах явцад ямар нэгэн асуудал тулгарвал Beijing Joyful Journey Technology(Group) Co.,Ltd. компанийн хэрэглэгчийн үйлчилгээний төв **(+86-4009209966-9, 7/24 цаг)** руу хандаж мэдээлэл авах боломжтой.